

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
2022 ОНЫ 7 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022.07.29.

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 3-ын аль нэгийг сонгож)тэмдэглэгээ хийх (√)			
		Тулгамдсан болон хоцорч буй ажил	УИХ, ЗГ-т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
I	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	Хуримтлалын нэгдсэн санг Монгол Улсад нэвтрүүлэх чиглэлээр үнэлгээ хийх, Монголд тохирсон хуримтлалын нэгдсэн сангийн загвар боловсруулах хүрээнд Дэлхийн банкны төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангах төсөлтэй хамтран ажиллав.			√	
2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус үндэсний зөвлөлийн ажиллах журам батлах, тогтоолын төслийн хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг боловсруулж яамдаас санал авч ЗГХЭГ-т хүргүүлсэн.		√		
3.	“Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам”-ын болон Засгийн газрын тогтоолын төсөл Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 6-ны хуралдаанаар хэлэлцэн батлагдав.		√		
4.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд яамдаас ирсэн саналыг нэгтгэж, төсөлд тусгахаар ажиллаж байна. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдөр 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, мэргэжилтэн 68 хүн, Хүүхдийн оролцооны Майхант цугларалтын оролцогч 550 хүүхдэд танилцуулж, санал авлаа.			√	
5.	Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл дээр зөвлөхүүдийн хамт ажиллаж байна.			√	
II	Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр				
6.	Амьгүй донор болсон бол оршуулгын тэтгэмжийн хэмжээг 3,5 сая төгрөгөөр тооцож олгодог байх зохицуулалтыг тогтоолын төсөлд тусгах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.			√	
7.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 7 сарын 25-ны А/143 дугаар тушаалаар “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт 08-д”-д нэмэлт, өөрчлөлт оруулав. YAMAT-08-д ejob платформын хөгжүүлэлттэй холбогдуулан хөдөлмөр зуучлалд түгээмэл хэрэглэгдэж байгаа ажил, мэргэжил болоод хүүхдийн зуслан, хүүхэд, гэр бүлийн асуудлаар нийт 75 ажил, мэргэжил шинээр нэмэгдэж, 16 ажил, мэргэжлийн нэршилд өөрчлөлт орсон.			√	
8.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь ТТ 9893-МОН” төслийн хүрээнд “Нийгмийн халамжийн салбарын мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт”-ыг Булган, Орхон, Хөвсгөл, Баян-Өлгий, Ховд, Увс, Хэнтий, Дорнод болон Сүхбаатар аймгийн ХХҮГ-т зохион байгуулж, аймаг, сумдын нийгмийн халамжийн мэргэжилтнүүдийг хамруулав.			√	

9.	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх, Ижоб платформыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл зэрэг холбогдох албан тушаалтнуудыг оролцуулсан уулзалтыг 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж, уулзалтын бэлтгэл ажлыг хангав. Уулзалтаар ижоб платформын ажлын явцтай танилцаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэв. Одоогийн байдлаар системийн хөгжүүлэлт, модулиудын хөгжүүлэлтийн ажлууд 42%, төслийн нийт гүйцэтгэл 66%-тай байна.			√	
10.	Аж ахуйн нэгж, байгууллагын 2022 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт шаардлагатай гадаад ажиллах хүчинд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, мөн УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх зохицуулалтыг бий болгохоор "Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 339 дүгээр тогтоолыг хүчингүй болгох, тоо хэмжээнд хязгаарлалт тогтоохгүй байх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн ээлжит хуралдаанд хэлэлцүүлж, батлуулав.			√	
11.	”Журамд нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2022 оны 80 дугаар тогтоолын дагуу аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлж эхлээд байна. Тайлант хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/132, А/142 дугаар тушаалуудаар нийт 46 аж ахуйн нэгж, байгууллагын 497 гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөв.			√	
12.	“Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам”-ын төслийг сайжруулж, батлуулахаар бэлтгэв. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн 2022 оны эхний хагас жилийн тайланг нэгтгэн, мэдээлэл бэлтгэв.			√	
13.	“Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 218 дугаар тогтоолын 6 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2022 оны А/145, А/261 дугаар хамтарсан тушаал батлуулж, ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулж, уулзалтаар нийслэлийн цэцэрлэгийн хүртээмж багатай 7 дүүрэгт хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлж, 2-3 настай 2000 хүүхдийг нэмж авахаар шийдвэрлэсэн. Шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Нийслэлийн Засаг даргад хамтран ажиллах хүсэлт албан бичгээр, ЗГХА-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нийслэлийн цэцэрлэгийн хүртээмж багатай 7 дүүрэгт хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэл хүргүүлж байна.			√	
14.	Залуучуудын анхан шатны үйлчилгээний бүртгэл, захиргааны статистикийн бүртгэлийг нөхөх зааврыг шинэчлэн батлуулав.			√	
15.	Хориг ял эдэлж буй суллагдах хугацаа дөхсөн хоригдлыг гэр бүл, ажил, нийгмийн харилцаанд бэлтгэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн төсөлд прокурор, цагдаа, бүртгэлийн байгууллагаас санал авч, тусган эцэслэн, төслийг баталгаажуулахаар ХЗДХЯ-тай хамтран ажиллаж байна.			√	
16.	Гэр бүл, эмэгтэйчүүд хүүхдэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд зориулсан хэлэлцүүлэг, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах талаар Төрийн нарийн			√	

	бичгийн даргын “Хэлэлцүүлэг, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, төсөв батлах тухай” 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/138 дугаар тушаалыг батлуулав.				
III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр				
17.	Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх ВЭБ-д суурилсан програм хангамжийг хөгжүүлэх хүрээнд Дэлхийн банкны төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангах төсөл болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллав. Нийгмийн даатгал болон халамжийн байгууллагад нийлүүлсэн 58 киоск машиныг суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.			√	
18.	Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын дэргэд ажиллах нэг талаас ажил олгогч, даатгуулагч, нөгөө талаас нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрүүг хянан шийдвэрлэх “Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм”-ийн төслийг 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 266 дугаар тогтоолоор батлуулав. Энэхүү дүрмийг хэрэгжүүлж ажиллахыг НДЕГ-т 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 02/1950 тоот албан бичгээр чиглэл хүргүүлэв.		√		
19.	Монгол Улсын онцлогт нийцсэн хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоо бий болгох чиглэлээр зөвлөх үйлчилгээ авахаар Хуримтлалын нэгдсэн сангийн хамгийн сайн туршлага бүхий Сингапур Улсын Сингапурын хамтын ажиллагааны байгууллагатай 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Хамтран ажиллах санамж бичигт 2 тал гарын үсэг зурлаа. Энэхүү Хамтран ажиллах санамж бичгийн дагуу Сингапурын хамтын ажиллагааны байгууллагаас авах зөвлөх үйлчилгээ нь 3 үе шаттай байх юм.			√	
20.	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг 2022 онд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/47 дугаар тушаалаар байгуулав. Төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Батлан хамгаалахын сайд нараар 2022 оны 03 сарын 22-ны өдөр батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төслийг 2022 оны 06 сарын 09-ний өдрөөс эхлүүлэн нийт 12 ээлжээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, ээлжийн хуваарь батлуулав. Төсөлд хамрагдах залуучуудын бүртгэлийн үйл ажиллагааг 2022 оны 05 сарын 16-ны өдрөөс 26-ны өдрийн хооронд www.e-mongolia.mn цахим системээр бүртгэн, сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа. Төслийн нэгдүгээр ээлж 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр 238 оролцогчтойгоор Зэвсэгт хүчний 119 дүгээр анги дахь төслийн хотхонд үйл ажиллагаа эхэлсэн. Мөн төслийн хоёрдугаар ээлж 06 дугаар сарын 25-ны өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хүртлэх хугацаанд I, II дугаар ээлж хүлээн авч, нийт 21 аймаг 9 дүүргийн 306 залуучууд хамрагдаад /үүнээс эрэгтэй 102, эмэгтэй 204/ байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Батлан хамгаалахын сайдын хамтран баталсан ерөнхий хуваарийн дагуу хичээл сургалтын үйл ажиллагаа цагийн хуваарь, төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдаж, зэвсэгт хүчний 58 албан хаагч, чиглүүлэгч багш 8, судалгааны ажилтан 5, бүлгийн удирдагч багш 12 гэсэн бүрэлдэхүүнтэйгээр төслийн үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Оролцогчдын дунд хийсэн зарим нэг судалгааны үр дүнгээс дурьдвал: Нийт 306 оролцогчоос 86 буюу 28,1 хувь нь мэргэжил эзэмшсэн бөгөөд үүнээс сонгосон мэргэжилдээ сэтгэл хангалуун 70 буюу 81,3 хувийг эзэлж байсан, мөн 3-4 ам бүлтэй өрх 20,5 хувийг эзэлж байна. Нийт оролцогчдын 64,7 хувь нь огт гэрлээгүй байна. Бизнес аялалд 89 оролцогчийг хамруулан Үндэсний үйлдвэрлэгч “Гоёл кашмер” ХХК-ийн үйлдвэр, нэрийн барааны дэлгүүрийн үйл ажиллагаатай танилцуулах ажлыг зохион			√	

	<p>байгуулсан. Ажил олгогчийн буланг ажиллуулж хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл болон нээлттэй ажлын байрны зарыг 18 аймаг, 3 дүүргээс авч 446 ажил олгогчийн 1014 ажлын байрны зарыг судалгааны багийн 5 ажилтан 306 оролцогчид хичээлийн боломжит цагаар танилцуулж 8 төрлийн гарын авлагаар хангаж ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээллийг 121 оролцогчид өгч бүртгэлийн дэвтэр нээж ажилласан.</p> <p>Үүний үр дүнд оролцогчид өөрийн аймаг, дүүрэгтээ дадлага хийх ажил олгогчдын мэдээллийг авч дадлага хийх боломжоор хангагдсан.</p> <p>Мөн нийт оролцогчдын профайлинг үнэлгээний нэгтгэлээс харахад ажилд шууд зуучлагдах боломжтой буюу хувиараа хөдөлмөр эрхлэх боломжтой иргэн 77, Ажилд зуучлах буюу хувиараа хөдөлмөр эрхлэхэд богино хугацааны үйлчилгээ, дэмжих арга хэмжээ шаардлагатай иргэн 116, Ажилд зуучлах буюу хувиараа хөдөлмөр эрхлэхэд урт хугацааны үйлчилгээ, дэмжих арга хэмжээ шаардлагатай иргэн 40, Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх боломжгүй иргэн 6 оролцогч байна. Төсөлд оролцогчид өөрийгөө илэрхийлэх чадвар, өөртөө итгэх итгэл, хөдөлмөрийн сэдэл нэмэгдсэн байгаа нь профайлингийн ярилцлага хийх үед нийтлэг байдлаар ажиглагдсан нь төслийн эерэг үр дүн байв. 31 ажил олгогчийн 1473 ажлын байрыг танилцуулж, 152 оролцогч анкет бөглөж, 210 оролцогчийг ажлын ярилцлагад хамруулж, 73 оролцогч дадлагажих гэрээ байгуулсан бөгөөд мөн 7 аймгийн 322 ажил олгогчийн 991 ажлын байрыг танилцуулж, 56 оролцогчийг тухайн ажлын байруудад бүртгэсэн. Мөн оролцогч залуусын хувьд урт хугацааны ажилгүйдэлд өртсөн, ажилд ороход хүндрэлтэй иргэдийн төлөөлөл их байсан. Төсөлд хамрагдсан оролцогчдын хоорондын харилцаа, хандлага нэмэгдэж, нийгэмд эзлэх байр суурь, өөртөө итгэх итгэлтэй болж байна.Залуучуудад хувь хүний хөгжил, эх оронч үзэл, эрүүл, зөв амьдралын хэв маягийг эзэмших чадварыг сургалт, өдөр тутмын үйл ажиллагаагаар олгож байгаа нь сайшаалтай.</p> <p>Оролцогч залуучууд хамт олны дунд биеэ зөв авч явах, хүсэл мөрөөдөлдөө хэрхэн хүрэх, ажил хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзэл нэмэгдэж байгаа зэрэг эерэг үр дүн гарч байна. Төслийн 2-р ээлжийг 6 дугаар сарын 25-нд эхлэхээр бэлтгэл ажилдаа орсон байна. Төслийн 3-р ээлж 8 сарын 3-наас 16 хүртэл, 4, 5-р ээлж 8 сарын 20-ноос 9 сарын 2 хүртэл, 6, 7-р ээлж 9 сарын 5-наас 9 сарын 18 хүртэл, 8,9-р ээлж 9 сарын 21-нээс 10 сарын 4 хүртэл, 10,11-р ээлж 10 сарын 7-с 10 сарын 20 хүртэл хугацаанд зохион байгуулахаар төлөвлөн ажлын хэсэг бэлтгэл ханган ажиллаж, төслийн III ээлжийн бүртгэлийг хамрагдах хүсэлтэй залуучуудыг орон даяар нэгэн зэрэг төрийн үйлчилгээний цахим систем WWW.E-MONGOLIA.MN-ээр дамжуулан 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 22-ны өдрийг дуустал бүртгэл явагдаж байна.</p>				
21.	<p>Европын холбооны санхүүжилтээр НҮБХХ-ийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд “Үйлчлүүлэгчид чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ”-г нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд ажил хайгч, ажилгүй иргэдийн хөдөлмөрлөх хэрэгцээг тодорхойлох үйлчилгээ буюу профайлингийн үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэн, 2022-2023 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд иргэдийг хамруулах ажилтай уялдуулан иргэдэд үнэлгээ хийхээр тусган Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Энэхүү үнэлгээний мэдээлэл дээр үндэслэн цаашид төрөөс иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үзүүлэх үйлчилгээ, арга хэмжээний чиглэлийг тодорхойлж, шинэ үйлчилгээ нэвтрүүлэхэд орон нутагт ажиллаж буй мэргэжилтнүүдийн ажлын зохион</p>			√	

	байгуулалтад өөрчлөлт оруулж, шинэ аргазүйгээр ажиллах хэрэгцээ шаардлага гарч байна. Иймээс энэхүү шилжилтийн үйл явцад хяналт тавих, цаашид сайжруулах санал авах, түүнчлэн 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй шинэ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд орон нутгийн мэргэжилтнүүдээс санал авах зорилгоор Мониторингийн ажлыг 21 аймгийг төлөөлөх 6 аймаг , Улаанбаатар хотын 9 дүүрэгт 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 7 дугаар сарын 8-ны хооронд төслийн багтай хамтран ажиллав.				
22.	Монгол Улсын Засгийн газар болон Европын Холбоо хооронд байгуулсан Санхүүжилтийн хэлэлцээр (АСА/2019/42187)-ийн хэрэгжилтийг үнэлэх Европын холбооны зөвлөх багтай хамтран ажиллав. Санхүүжилтийн хэлэлцээрээр ХНХЯ нь энэ оноос нийт 2 шалгуур үзүүлэлтийн биелэлтийг ханган ажиллаж байгаа бөгөөд шалгуур үзүүлэлтийн биелэлтийг бүрэн хангаж байгаа болно.			√	
23.	Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийн тоон мэдээллийг нэгтгэн 2022 оны 1 дүгээр улирал, 2022 оны 06 сарын байдлаар гаргаж, www.misp.mn сайтад байршуулахаар холбогдох хэлтэст хүргүүлэв.			√	
24.	"Алсын Хараа - 2050" Урт хугацааны бодлогын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээнээс газарт хамаарах ажлын биелэлтийг гаргаж 7 дугаар сарын 1-ны өдрийн дотор холбогдох албан хаагчид хүргүүлэв.			√	
25.	Цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх салбар дундын ажлын хэсгийн хурлыг 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдөр зохион байгууллаа. Хурлын бэлтгэл ажлын хүрээнд "Бид хамгаална" загвараар цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг байгууллагуудаас авч нэгтгэсэн ба хурлын үеэр Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, гарц шийдлийг хэлэлцэв.			√	
26.	ЗГХА-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-ын хэрэгжилтийн 2022 оны эхний хагас жилийн тайлантай танилцаж, журмын хэрэгжилтийн тайланг дахин боловсруулж сайжруулах чиглэлийг хүргүүлсэн.			√	
27.	Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний хүрээнд Дэлхийн зөн Монгол ОУБ, Гэрэл медиа групптэй хийсэн уулзалтад оролцож, цаашид нөлөөллийн төлөвлөгөөнд санал өгөх, шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган хамтран ажиллаж байна. Техникийн ажлын хэсгийн хурлыг хийв.			√	
28.	Үндэсний хэмжээнд 2022 оны 9 дүгээр сард зохион байгуулах "Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын минимум стандартын сургалт" зохион байгуулахад шаардлагатай зардлыг НҮБ-ын Хүүхдийн сангаар шийдвэрлүүлэв.			√	
29.	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2022 оын 07 дугаар сарын 05 ны өдрийн А/136 тоот тушаалаар Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай тушаалыг батлуулж 2022 оны 07 дугаар сарын 06 ны 02/1851 тоот албан бичгээр ЗГХА-Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газарт Үндэсний их баяр наадам болон аймаг сумын баяр наадмын үед уралдаанч хүүхдийн даатгал, стандартын шаардлагад нийцсэн хамгаалалтын хувцас хэрэгсэлд хяналт тавьж бүртгэн, уралдааны зохион байгуулалт хүүхдийн аюулгүй байдлыг хангасан эсэхэд хяналт тавьж ажиллах чиглэл хүргүүлэв.			√	
30.	Нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулав.			√	

31.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбарт хүний эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан гаргав.			√	
32.	Монгол Улс “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах” тухай олон Улсын гэрээ конвенцид 1981 онд нэгдэн орсон. Засгийн газрын төлөөллийн бүрэлдэхүүн тус конвенцын ээлжит 10 дугаар тайлангийн хэрэгжилтийг НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах хорооны 82 дугаар хуралдаанаар 2022 оны 06 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд хэлэлцүүлэн, амжилттай хамгаалсан бөгөөд Хорооноос ирүүлсэн зөвлөмжийн төсөлд салбаруудаас санал авч тусган боловсруулж, ГХЯ-нд хүргүүлсэн. Ерөнхий сайдын 2022 оны А/77 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан Засгийн газрын гишүүдэд тус яамнаас “талархал дэвшүүлсэн” албан тоотыг хүргүүллээ.			√	
33.	Хууль зүй, дотоод хэргийн яам Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн нэмэлт санхүүжилтийн төслийн хүрээнд 20 бичил тэтгэлэгт төсөл сонгон шалгаруулах ажлын сонгон шалгаруулалтын үнэлгээг хийсэн. Нийт саналаа ирүүлсэн 46 төсөлд үнэлгээ хийсэн.			√	
34.	Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд “хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх” дэд зөвлөл, “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг бэлтгэн хүргүүллээ.			√	
35.	Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчийн тал хувь нь ажилгүй иргэд байгаа тул эдгээр иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байранд зуучлах, шаардлагатай тохиолдолд Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж, тухайн орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /хэлтэс/-тай хамтран ажиллахыг чиглэл болгосон албан тоотыг хүргүүллээ.			√	
36.	ХЗДХЯ-наас ирүүлсэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Засгийн газрын ээлжит 7 дахь тайлангийн төсөлд санал өгөв.			√	
37.	“Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ын төсөлд санал өгөв.			√	
38.	Нийгмийн үйлчилгээ үзүүлдэг салбарын байгууллага /ТХБ, НЦҮТ болон хүүхдийн асрамж, халамжийн байгууллага/-ын бүртгэл судалгааг гаргаж, ГХАОНХХ-т өгөв.			√	
39.	"Олон улсын хүүхдийн Найрамдал-2" зуслангийн зураг төслийн 3D видео танилцуулгыг хийж гүйцэтгэсэн Скайлайн дизайн ХХК-ны зөвлөхүүдтэй ажиллав.			√	
40.	“Тархины саажилт, уналт таталттай хүүхдийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулж ХНХ-ын сайдын “Санал өгөх тухай” 01/1814 тоот албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн.			√	
41.	УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгийн санаачилгаар энэ оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан “Сувилагчид ээлтэй Монгол” сувилахуйн үндэсний чуулганаас гарсан зөвлөмжийг Төрийн нарийн бичгийн даргын 3/1936 тоот албан бичгээр ХБХХЕГ, ХБХСЗХТ, СЗСҮТ-д хүргүүлэв.			√	
42.	МУ-ын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 33 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулан, яамдаас санал авахаар ажиллаж байна.			√	

43.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоо, хамгааллыг сайжруулах чиглэлээр Мобиком корпораци ХХК-тай 2019 онд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүчинтэй хугацаа 2021 онд дуусгавар болсон. Тус гэрээг үргэлжлүүлэн 2022-2023 онд хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагын албаны төлөөлөгчидтэй цахим уулзалтыг зохион байгуулж, санамж бичгийн төсөл, үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, гэрээг байгуулахаар ажиллаж байна.			√	
44.	-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн статистик мэдээллийн нэгдсэн сангийн эхний хувилбарыг 21 аймаг, 9 дүүргийн салбар комиссын нарийн бичгийн дарга нарт танилцуулах онлайн сургалтыг зохион байгуулав. -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн статистик мэдээллийн нэгдсэн сангийн эхний хувилбарыг ХБХЭМБНХК-ын хуралдааны явцад туршиж, мэдээллийн сантай холбоотой салбар комиссын гишүүдийн саналыг нэгтгэж START II төсөл, программ хангамжийг хөгжүүлэгчид хүргүүлэв. -Эмнэлэг хөдөлмөр магадлах төв комиссын программ хангамж, мэдээллийн сантай танилцах хүсэлтийг ЭХМТК-Т хүргүүлсэн.			√	
45.	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх” төслийн удирдах хорооны хурлыг зохион байгуулж, 2022 оны эхний хагас жилийн ажлыг дүгнэж, сүүлийн хагас жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцлээ.			√	
46.	Азийн хөгжлийн банкны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2”-оос улсын хэмжээнд өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд мэдээллийн технологийн 3 зөвлөхтэй уулзалт зохион байгуулж, хийх ажлын төлөвлөгөөнд санал тусгаж, ӨМНС-ийн системийн зохиомж, хэрэглэгчийн шаардлагыг тодорхойлж байна.			√	
47.	Залуучуудын статистикийн маягт шинэчилж анхан шатны бүртгэлийн 1, бүртгэлийн 9, захиргааны 20 маягыг боловсруулж, ҮСХ-ны Аргазүйн байнгын зөвлөл болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулав.			√	
48.	Хүүхдийн статистикийн аргачлалын төслийг эцэслэн боловсруулж, ҮСХ-ны Аргазүйн байнгын зөвлөл болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулахаар хүргүүлсэн. Мөн аргачлалын төсөлд санал авахаар Холбогдох төрийн байгууллагууд руу албан бичиг илгээн, санал авч саналуудыг тусган ажиллаж байна.			√	
49.	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэх ажлын хүрээнд, Дэд сайдаар ахлуулсан том ажлын хэсгийн хуралд оролцож, дэд ажлын хэсгийн 4 удаа уулзалт хийж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн тайлангийн 30 маягт боловсруулж, хөдөлмөрийн статистикийн чиглэлээр санал өгч ажиллав.			√	
50.	Яамны цахим хуудсын статистик, холбоо барих, мэдээ мэдээлэл, ил тод болон бодлого чиглэл хэсэгт нийт 14 мэдээлэл оруулав				